

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНААС 2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Ажлын алба тайлант хугацаанд Хурлын Зөвлөлийг шинээр байгуулж, Хурал, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, Хурлын хороодоос зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Гамшгийн эрсдлийг бууруулах, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах, Авлигатай тэмцэх, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон мэргэшүүлэх сургалтын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг тус тус боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ээлжит наймдугаар, есдүгээр, аравдугаар, арваннэгдүгээр, ээлжит бус дөрөвдүгээр, тавдугаар хуралдаануудыг тус тус зохион байгуулж, дүүргийн Засаг даргаас өргөн барьсан 18 (давхардсан тоогоор), Хурлын Ажлын албанаас өргөн барьсан 5 нийт 23 асуудлыг хэлэлцэн баталлаа.

Хурлын хуралдаанаас баталсан шийдвэрийг дурдвал:

1. Дүрэм, журмууд:

- “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Чингэлтэй дүүргийн “Хүүхдийн номын өргөө” төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газрын нэрийг өөрчилж, дүрмийг шинэчлэн батлах тухай;
- Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг батлах тухай;

2. Зохион байгуулалтын чиглэлээр:

- Хурлын Зөвлөл байгуулах тухай;
- Хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг шинэчлэн тогтоох тухай;
- Хамтарсан баг байгуулах тухай;
- Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл байгуулах тухай;
- Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай;
- Чингэлтэй дүүргийн бэлгэдлийг батлах тухай;
- Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, 2024 оны төлөвлөгөө батлах тухай;

- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэдийг оролцуулах тухай;

3. Төсөв санхүүгийн чиглэлээр:

- Тогтоолд өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай;
- Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай;

4. Бусад:

- “Алдарт эх”-ийн одонгоор шагнуулах эхчүүдийг уламжлах тухай;
- Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай;

Хурлын хуралдаанаас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 90-100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 15, 50-90 хувь буюу хэрэгжих шатандаа 7 тогтоол байна.

Тайлант онд хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Зөвлөлийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит есдүгээр хуралдааны 08 дугаар тогтоолоор байгуулан, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Б.Мөнхбат, Д.Ядамжав, Н.Бямбагэрэл, Ч.Ариунчимэг, Б.Болортунгалаг, Н.Доржпүрэв, Т.Найдан нар сонгогдон ажиллаж байна.

Хурлын Зөвлөл тайлант онд 10 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 41 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээс 39 асуудлыг хэлэлцэж, давхардсан тоогоор зохион байгуулалтын 4, Хурлын хорооны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах 1, нийт 5 тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.

Хурлын Зөвлөлөөс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 90-100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 5 тогтоол байна.

Хурлын байгууллагын тасралтгүй, байнгын, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын хороод тайлант хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр 72 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 6 удаагийн удирдамж, төлөвлөгөөний дагуу 69 ажлыг зохион байгуулж, биелэлт 95,8 хувьтай байна. Түүнчлэн хурлын хороод хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлт гаргасныг дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Хурлын хороодоос зохион байгуулсан ажлаас дурдвал:

1.Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Дүүргийн Үйлдвэрчний Эвлэлийн хорооны үйл ажиллагаатай танилцах;
- Хороодын хэсгийн ахлагч нартай төвлөрсөн уулзалт зохион байгуулж, санал солилцох;
- Чингэлтэй дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тайлантай танилцах;
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцах;
- Олон улсын хүний эрхийн өдрийг угтаж дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулах;
- “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;
- “Гамшиг, эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх хүрээнд:

- “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Чингэлтэй дүүргийн “Хүүхдийн номын өргөө” төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газрын нэрийг өөрчилж, дүрмийг шинэчлэн батлах тухай;
- Энгийн хог хаягдлын үйлчилгээний хурамжийн хэмжээг батлах тухай;

Зохион байгуулалтын асуудлаар:

- Хурлын хорооны даргыг чөлөөлж, шинээр сонгох тухай;

2.Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Дүүргийн 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлж байгаа ажилтай танилцах;
- Дүүргийн санхүү, төсвийн үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн татварын бодлого, үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээтэй танилцах;
- Дүүргийн Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнтэй танилцах;
- Дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран дүүргийн харьяа цэцэрлэгүүдийн зөөлөн эдлэл, хөнжил, гудсыг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг санхүүжүүлэх;

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх хүрээнд:

- Тогтоолд өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн 2023 оны тогтоолд өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн 2024 оны төсвийн төсөл;

3.Төсвийн зарцуулалтын хяналтын хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Дүүргийн ОНӨТҮГ-уудын 2022 оны ажлын тайлантай танилцах;
- Дүүргийн татварын бодлого, үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнтэй танилцах;
- Дүүргийн Дотоод аудитын албаны үйл ажиллагаа, 2022 оны аудитын тайлан, аудитын зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажилтай танилцах;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалттай танилцах;
- Улс, Нийслэл, дүүрэг, ОНХС-ийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй дүүрэгт 2022 онд хийгдсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, 2023 он, 2022-2023 он дамжин хийгдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилттэй танилцах, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх;

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх хүрээнд:

- Дүүргийн 2022 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлтэй танилцах;

4.Ногоон хөгжил, газрын харилцааны хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Тохижилт, орчны цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа, Газрын тухай хуулийн хэрэгжилттэй танилцах;
- Чингэлтэй хайрхны ойжуулалт, булаг, шандын хамгаалалтын үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн агаар, хөрс, орчны бохирдлын чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажил, цаашид авах арга хэмжээтэй танилцах;
- Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, байгаль хамгаалал, нөхөн сэргээх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын явц байдалтай танилцах;
- “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнтэй танилцах;

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх хүрээнд:

- Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2024 оны төлөвлөгөөний төсөл;

Зохион байгуулалтын асуудлаар:

- Хурлын хорооны даргыг чөлөөлж, шинээр сонгох тухай;

5. Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах;
- Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлтэй танилцах;
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах;
- Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулах;
- “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүн;
- “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;
- Дүүргийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын дунд “Эко шийдэл-Хоггүй ирээдүй” уралдаан;

6. Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Ахмад настны хөгжлийг дэмжих чиглэлээр өдөрлөг, үйл ажиллагаа зохион байгуулах-/сургалт, хэлэлцүүлэг/;
- Хороодын өрхийн эрүүл мэнд ийн төвийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт, санхүүжилттэй танилцах;
- Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, явц, хэрэгжилттэй танилцах;
- “Хүүхдийн номын өргөө” ОНӨТҮГ-ын шинэчилсэн дүрмийн төсөл;
- Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр өдөрлөг, үйл ажиллагаа зохион байгуулах /сургалт, хэлэлцүүлэг/;
- Дүүргийн төрийн байгууллагуудын цахим үйлчилгээний хэрэгжилт, явц үр дүнтэй танилцах;
- Халдварт өвчин болон амны хөндийн эрүүл мэндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж байгаа ажилтай танилцах;
- Дүүргийн ЕБС, СӨБ-ын 2023-2024 оны хамран сургах тойрог, хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилтай танилцах;

- Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодын Эрүүл мэндийн даатгалгүй, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чаддаггүй, нөхөн үржихүйн 20-50 насны эрсдэлт бүлгийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, тэдний эрүүл мэндийг хамгаалах, бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлж бүрэн эмчлэх, халдварын тархалтыг бууруулах, дүүргийн эрсдэлт бүлгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ;

7. Ёс зүй, өргөдлийн хороо

Төлөвлөгөөт ажлын хүрээнд:

- Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, байдалтай танилцах;
- Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, ур чадварын тадаар иргэдээс санал асуулга, тандалт судалгаа авах
- Төрийн албан хаагчдад “Ёс зүй, харилцаа хандлага, гадаад үзэмж бүрдүүлэлт” сэдэвт сургалт;
- Иргэдийн оролцоог хангах чиглэлээр зохион байгуулж буй ажилтай танилцах;
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооны үйл ажиллагаатай танилцах;

Хурлын хорооны санал дүгнэлтийн хүрээнд:

- Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, байдалтай танилцах;
- Дүүргийн Татварын хэлтэст иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, байдалтай танилцах;
- Дүүргийн Газар зохион байгуулалтын албанд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, байдалтай танилцах;

ХОЁР. ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ

Хурлын Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидтойгоо ажиллах нөхцөлийг бүрдүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх хүрээнд: “Эртэч Чингэлтэйчүүд”, “Шийтгэл бол шийдэл биш”, “Тэрбум мод”, “Хашаандаа мод таръя” 4 удаагийн аян, Үндсэн хуулийн өдөр, Сар шинэ, “Амар байна уу-2023”, “Чингэлтэй фестиваль-2023”, “Иргэний андгай өргөх ёслол”, “Бүтээлч дүүрэг” үйл ажиллагаа, “Хичээлийн шинэ жил”, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, “Залуучуудын сонголт бидний ирээдүй” зэрэг 10 удаагийн нэгдсэн арга хэмжээ, Бүгд Найрамдах Япон, Солонгос, Турк, Хятад Улс, Америкийн нэгдсэн Улс, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсад айлчлах 8 удаагийн гадаад арга хэмжээнд 27 Төлөөлөгчийг, Газрын багц хууль, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг, “Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форум, “Хүний эрхийн

манлайлагч-Төлөөлөгч”, “Төлөөлөгчийг чадавхжуулах”, “Залуучуудын сонголт бидний ирээдүй”, “Чингэлтэйн залуус бид хамтдаа”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” зэрэг нийт 7 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, 8 удаагийн “Мэдээллийн цаг” арга хэмжээнд Хурлын Төлөөлөгчдийг оролцууллаа.

Мэдээллийн цаг арга хэмжээний хүрээнд Хурлын Төлөөлөгчид дүүргийн Улсын бүртгэл, Статистик, Татварын хэлтсүүд, Албан-бус Насан туршийн боловсролын төв, Биеийн тамир, спортын хороо болон Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв, Монголын Үндэсний музейн үйл ажиллагаатай танилцлаа.

Хурлын Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидтойгоо ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тэдний тойрогтоо ажилласан байдлыг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402, 2022 оны 404 дүгээр тогтоолыг үндэслэн жилд нэг удаа, үйл ажиллганы зардал болон Хурлын Зөвлөлийн гишүүдийн урамшууллыг сар тутам, Хурлын хороодын үйл ажиллагааны зардлыг тухай бүр Хурлын төсвөөс тус тус санхүүжүүлж ажиллалаа.

Тайлант онд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд иргэд, олон нийтэд чиглэсэн, үр дүн бүхий сургалт, үйл ажиллагаа, арга хэмжээнд Хурлын Төлөөлөгчдийг тухай бүр хамруулан, хамтран ажиллалаа. Үүнд:

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсны 31 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хууль батлалцсан Чингэлтэй дүүргийн харьяат, тухайн үеийн Ардын Их Хурлын депутатуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, дүүргийн 30 жилийн ойн медаль гардууллаа. Мөн хороодын 18-35 насны 40 гаруй иргэдийн дунд Үндсэн хуулийг сурталчлах, тус хуулийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх хүрээнд “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон хороодын иргэдийн Нийтийн Хурлын ахмад дарга, дүүргийн харьяа ахмад настуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа.

Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль сурталчлах, Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд нийгэм дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, гоо зүйн мэдрэмжийг бий болгох, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Эрхэмсэг бүсгүй танд” нэгдсэн арга хэмжээг дүүргийн 1-24 хорооны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд 120 гаруй эмэгтэй хамрагдлаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлан таниулах, “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” Олон Улсын өдрийг тохиолдуулан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургуулийн орчин болон эрсдэлт нөхцөлд байгаа сурагчдын

аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Багш, хүүхэд, эцэг эхчүүд хамтдаа” 20 удаагийн 60 цагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж, хүүхдийг эерэг аргаар өсгөж, сурган хүмүүжүүлэх зөвлөмж, мэдээлэл бүхий гарын авлагаар хангаж ажиллалаа. Тус арга хэмжээнд 6000 гаруй иргэд оролцсон байна.

Түүнчлэн дүүргийн ерөнхий боловсролын сургалтын агуулга дахь урлагийн төрлүүдийг уялдуулан ойлгуулах, өөрийн орны болон дэлхийн сор болсон бүтээлүүд, тэр дундаа өсвөр насныхны сонирхол бүхий бүтээлүүдийг мэргэжлийн уран бүтээлчдийн тоглолттойгоор тайлбарлан таниулах, хөгжмийн урлагаар дамжуулан хүүхдүүдэд соёл урлагийн боловсрол олгох, сонгодог урлаг, хөгжмийн ирээдүйн хүний нөөц, чадварлаг мэргэжилтэн бэлтгэх, нээн илрүүлэх зорилго бүхий “Хөгжим-хүүхдийн боловсролд” үзүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Хүүхдийн эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах, Олон Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн ерөнхий боловсролын 15 сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад хүүхдийн эрх, хамгаалал, багш, эцэг эхчүүдэд хүүхдийг эерэг аргаар өсгөж, сурган хүмүүжүүлэх зөвлөмж бүхий “Хүүхдээ хамгаалъя” материалыг хэвлүүлэн, тарааж Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлан ажиллалаа. Мөн “Хүүхэд бидний ирээдүй” өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж, Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны албан хаагчдын 90 хүүхэд хамрагдлаа.

Мөн өдрийг тохиолдуулан дүүргийн харьяат 16 насанд хүрч буй хүүхдүүдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагыг ухамсарлах, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилго бүхий “Иргэний андгай өргөх ёслол”-ыг зохион байгуулж, 200 хүүхэд хамрагдсан байна.

Гэр бүлийн тухай хуулийг сурталчлан таниулах, Олон Улсын Гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учрыг сурталчлан таниулах, дүүргийн иргэд, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор дүүргийн онцлох 9 гэр бүлийн дунд “Аз жаргалтай гэр бүл” гэрлэх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах, Олон улсын Залуучуудын өдрийг тохиолдуулан залуучуудыг хөгжүүлэх, хувь хүний амжилтад хүрэх сэтгэлзүйг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, дэвшүүлсэн санал, санаачилгыг дэмжих, мэргэжил сонгох, гадаад, дотоодын их дээд сургуулийн тэтгэлэгт хамрагдах, тэдний дуу хоолой, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Залуучуудын сонголт бидний ирээдүй” сэдэвт сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, дүүргийн 140 гаруй залуус хамрагдсан байна.

Мөн дүүргийн 1-24 дүгээр хороодын залуучуудын дунд хувь хүний хөгжил, боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Чингэлтэйн залуус бид хамтдаа” чуулга, уулзалтыг зохион байгуулж, дүүргийн 1500 гаруй залуучууд хамрагдлаа.

Ахмад настны тухай хуулийг сурталчлах, Олон Улсын Ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн шалгаруулах журам”-ын хүрээнд дүүргийн Ахмадын хороотой хамтран, ахмадын байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож, ахмадуудад дэмжлэг туслалцаа үзүүлсэн Чингэлтэй дүүргийн 13, 15, 19 дүгээр хороодын нийт 3 аж ахуйн нэгж байгууллагыг “Ахмад настанд ээлтэй байгууллага”-аар, 3, 11 дүгээр хорооны 2 иргэнийг “Ахмад настанд ээлтэй иргэн”-ээр тус тус шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Мөн өдрийг тохиолдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон Хороодын иргэдийн Нийтийн Хурлын ахмад дарга нарт хүндэтгэл үзүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах хүрээнд тэдний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангаж, хүртээмжтэй байдлаар төрийн үйлчилгээг авах, үйлчлүүлэх боломжийг сайжруулахад шинэлэг, бүтээлч санал, санаачилгуудыг дэмжиж төр, иргэний хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш боломжийг олгоё” аяныг зарлаж, дээрх шалгуур шаардлагыг хангасан 5 хороог шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, гэмт хэрэг, гэр бүлийн орчинд үйлдэгдэж буй хүчирхийлэл түүний хэлбэрүүд, илрэх шинж тэмдэг, яаралтай тусламжийн утас, хамтарсан багийн талаарх мэдээллийг брайл үсгээр хэвлүүлэн дүүргийн харааны бэрхшээлтэй иргэдэд хороод, хороодын хамтарсан багаар дамжуулан тараалаа.

Хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах хүрээнд хүүхдийн эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах, хүүхэд эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий тараах материал 1000 ширхгийг хэвлүүлэн тараалаа.

Улс тунхагласны баяр болон Монгол бахархлын өдрийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хүсэл сонирхол, дуу хоолойг сонсох, Монгол ёс заншил, тусгаар тогтнол, эх оронч үзлийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор бага, дунд ангийн сурагчдын дунд “Монгол бахархал” сэдэвт гар зургийн, ахлах ангийн сурагчдын дунд “Тусгаар тогтнол” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг тус тус зарлаж, 204 бүтээл ирүүлснээс 9 бүтээлийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.

Тайлант онд УИХ, Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон Төлөөлөгчдийн саналаар иргэд сонгогчидтой хийх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд Хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд иргэд олон нийтийн саналыг тусгах, Хөрсний бохирдлыг бууруулах “Асуудал шийдэл” сэдэвт сонсгол, хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, 2390 (давхардсан тоогоор) иргэн хамрагдсан байна.

Дүүргийн хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, иргэн, гэр бүл, байгууллага, хамт олныг эрүүл амьдрах хэв маягт төлөвшүүлэх, бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд олон нийтийн оролцоог дэмжих зорилго бүхий “Эртэч Чингэлтэй” аяны хүрээнд 4 удаагийн явган алхалтыг зохион байгуулж, 3500 гаруй ажилтан албан хаагч, иргэд хамрагдсан байна.

Мөн агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах, хотын тохижилт, ногоон байгууламжийн менежментийг сайжруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар иргэдийн ая тухтай орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангах, амьдралын шинэ дадал хэвшил төлөвшүүлэх зорилго бүхий “Хашаандаа мод тарья” аяныг зарлаж, дүүргийн 354 өрхийн ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.

Түүнчлэн иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах хүрээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Эцэг эхийн зөвлөл, Эмэгтэйчүүдийн зөвлөл, дүүргийн Ахмадын хороо, Улаан загалмайн хороо, Монголын Эмэгтэйчүүдийн холбооны үйл ажиллагаа болон дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотын Чөлөөт бүс рүү илгээх ачааны зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.

Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 384 жилийн ойн өдрийг тохиолдуулан гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учрыг сурталчлан таниулах, иргэд, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор дүүргийн шинээр гэрлэлтээ батлуулж байгаа 10 гэр бүлийн дунд “Гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслол”-ын арга хэмжээг зохион байгууллаа.

Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд дүүргийн хөгжилд иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, тэдний оролцоотойгоор иргэдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, иргэд, олон нийтийн шинэлэг, бүтээлч санал, санаачилгуудыг дэмжиж төр, иргэний хамтын ажиллагааг өрнүүлэх зорилгоор “Иргэний оролцоотой бүтээлч Чингэлтэй” аяныг зарлаж, дүгнэж урамшууллаа.

Тайлант онд Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хангарди-2023”, дүүргийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын 5 төрөлт “Спорт наадам”, Улаанбаатар Марафон”, зэрэг спортын тэмцээн, уралдаанд Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны албан хаагчид тус тус амжилттай оролцлоо.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн удирдамжийн хүрээнд Монгол Улсын шинэ үндсэн хууль батлагдсан өдрийг угтаж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатар сонирхогчдын “Дүүргийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тус тэмцээнээс шалгарсан эрэгтэй 6, эмэгтэй 3 шилдэг шатарчдыг Нийслэлийн шатар сонирхогчдын аварга шалгаруулах

тэмцээнд оролцуулахаар нэрсийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүллээ.

Тайлант онд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба 21 ажил зохион байгуулахаас 21 ажлыг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100 хувьтай байна.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хурлын Ажлын алба Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил, хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Хурлын Төлөөлөгчдийн хуралдаа ажиллах нөхцөл бололцоог хангах, техник зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх, зохион байгуулсан ажлыг иргэд олон нийтэд сурталчлах, төвлөрсөн болон хяналт шалгалтын бусад арга хэмжээг зохион байгуулах, Хурлын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн дагуу ажиллалаа.

Тайлант онд Хурлын Ажлын алба байгууллага, иргэдээс 578 бичиг тоот хүлээн авснаас 568 бичиг тоотыг хуульд заасан хугацаанд бүрэн шийдвэрлэж, 10 бичиг шийдвэрлэх шатандаа байна. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 588 бичиг тоотыг хүргүүлэн ажиллалаа.

Ирсэн бичгийг ангилбал:

- Дээд газраас -42
- Хурлын Төлөөлөгчдөөс- 34
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх, харьяа хэлтэс албад-60
- Дүүргийн Засаг дарга түүний Тамгын газар-68
- Дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх, харьяа хэлтэс албад, хороодоос-237
- Аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагаас-101

Хурлын Ажлын алба байгууллага, иргэдээс 6 хүсэлт, 8 гомдол, 12 өргөдөл хүлээн авснаас 5 хүсэлт, 1 гомдол, 11 өргөдлийг Хурлын Ажлын алба эрхлэх асуудлын хүрээнд бүрэн шийдвэрлэж, 1 хүсэлт, 7 гомдол, 1 өргөдлийг дүүргийн Засаг дарга түүний Тамгын газарт шилжүүлсэн бөгөөд харьяалах асуудалд хамаарахгүй 1 гомдлыг гомдол гаргагчид буцааж, 1 хүсэлтийг судлаж байна.

Шашин сүм хийдтэй харилцах чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагуудын судалгааг жил тутам шинэчлэн боловсруулж, мэдээллийн санд бүртгэн ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 38 байгууллага шашны үйл ажиллагаа явуулж байгаагаас Будда 17, Христ-21 байна.

Тайлант онд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийд, түүний дэргэдэх дотуур байрны үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох зөвлөмжийг боловсруулан шашны байгууллагуудад хүргүүлэн,

15 шашны байгууллагатай хариуцлагын гэрээг жилийн хугацаатай байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Мөн шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүссэн 12 байгууллагын өргөдөл, хүсэлтийг судлан, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төрийн дээд шагнал, цол, одон, медалаар шагнуулахаар байгууллага, иргэдээс ирүүлсэн Чингэлтэй дүүргийн харьяат 540 иргэн, “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат 423 эхийн тодорхойлолт материалыг тус тус хэлэлцэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулан, идэвх санаачилгатай ажиллаж байгаа Чингэлтэй дүүргийн харьяат 534 иргэний тодорхойлолт материалтай танилцаж 458 иргэнийг Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор, 76 иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшууллаа.

Тайлант хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд байгууллагын хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулахад 485,648,845.31 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 133,789,812.95 төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил, 51,300.000 төгрөгийн өртөг бүхий Авто тээврийн хэрэгсэл, 1,482,000 төгрөгийн өртөг бүхий программ хангамж, 49,449,181.10 төгрөгийн өртөг бүхий бараа материал, нийт 721,669,839.36 төгрөгийн өртөг бүхий өмч, эд хөрөнгө тоологдсон байна. Тооллогоор эвдэрсэн, үлдэх өртөггүй, актлах шаардлагатай 69 төрлийн 80,082,413,08 төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын зөвшөөрлийн маягтын дагуу данс бүртгэлээс хасах жагсаалтыг бэлтгэн хүргүүлээ.

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27.1.9 дэх хэсэгт заасан төрийн архивт нөхөн баяжилт хийх хуулийн хугацаа болсонтой холбогдуулан байгууллагын архивт хадгалагдаж байгаа 1992-2020 оны нийт 1,699 цахим болон цаасан суурьтай баримтад техник боловсруулалтын ажил хийж, цаасан суурьтай болон тусгай суурьт 302 хадгаламжийн нэгжийг төрийн архивт шилжүүлэхээр данс, бүртгэлийг үйлдэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хүлээлгэн өглөө. Мөн 2000-2020 оны 17 хэргийн 370 хадгаламжийн нэгжийг үлгэрчилсэн жагсаалтын дагуу устгах баримтын жагсаалт үйлдэн баталгаажуулж, устгууллаа.

Тайлант онд Хурлын дарга Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар 85 захирамж, Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга үндсэн үйл ажиллагаатай холбоотой 260, боловсон хүчинтэй холбоотой 101, нийт 361 тушаал, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах

хүрээнд Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийн хүрээнд нийт 18 албан хаагч ажиллаж байгаагаас Төрийн захиргааны 10, Төрийн үйлчилгээний 3, Улс төрийн 5 албан хаагчтай тус тус гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллалаа.

Тайлант онд Төрийн захиргааны 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, 6 албан хаагчид шинээр олгож, Засгийн газрын 2022 оны 487, 488, 491 дүгээр тогтоолын хүрээнд Төрийн захиргааны 11 албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлийг, 2023 оны 241 дүгээр тогтоолын хүрээнд төрийн үйлчилгээний болон улс төрийн нийт 22 албан хаагчийн цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, Төрийн захиргааны 1 сул орон тоог Төрийн албаны Нийслэл дэх салбар зөвлөлийн тогтоолын дагуу нөхөж, 1 албан хаагчийг шилжүүлэн, 7 албан хаагчийг өөрийнх нь хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлж, 9 албан хаагчийг төрийн албанд шинээр томилж, 5 албан хаагчийн нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэж, 8 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламжийг, 3 албан хаагчид цалинтай чөлөө олгож, 3 албан хаагчийг гадаад арга хэмжээний хөтөлбөрт тус тус хамрууллаа.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд “Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, ажлын зохион байгуулалт”, “Хууль, эрх зүйн мэдлэг олгох”, “Орон нутгийн бодлого төлөвлөлт ба үр дүнд суурилсан хяналтын тогтолцоо”, “Төсөв санхүү ба хариуцлага”, “Судалгааны арга зүй”, “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт, хяналт, шинжилгээний сертификат олгох сургалт”, “HR-2023” чуулга уулзалт, сургалтууд болон Төрийн албаны зөвлөлөөс пүрэв гариг бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа цахим сургалт, байгууллагаас зохион байгуулсан захиалгат “Эрүүл аж төрөх дадал” сургалтад албан хаагчдыг хамруулсан байна.

Тайлант онд Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 11 ажлыг зохион байгуулсан байна.

Дүүргийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжтэй, нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлэх, ижил төстэй байгууллагуудын ажлын туршлагыг судалж өөрийн ажилдаа нэвтрүүлэх хүрээнд “Гадаад дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан хэрэгжилтийг зохион байгууллаа.

Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд хамтын харилцаа бүхий Бүгд Найрамдах Солонгос, Турк, Хятад Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улс болон Оросын Холбооны Улсуудын Элчин Сайдын яамдтай захидал, цахим шуудангаар байнгын харилцаатай ажиллаж байна.

Тайлант онд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хурлын дарга Б.Мөнхбат, Төлөөлөгч Н.Батсүмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотод, Хурлын дарга Б.Мөнхбат тэргүүтэй төлөөлөгчид Оросын холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Улаан-Үдэ хотод, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотод, Япон Улсын Токио хотод, Бүгд Найрамдах Солонгос Улсын Чэжү мужид, Хурлын Төлөөлөгч Д.Отгонбаатар тэргүүтэй төлөөлөгчид Бүгд найрамдах Турк Улсын Кемир, Синжан дүүрэгт ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын үр дүнд Бүгд найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотын Ардын Төлөөлөгчдийн Их Хуралтай хамтын ажиллагаагаа сэргээж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, бүс нутгийн онцлог шинж чанартай бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах зорилгоор Манжуур хотын Хятад Оросын хилийн худалдааны бүсэд Чингэлтэй төвийг нээх, Манжуур хот нь Чингэлтэй дүүрэгт “Манжуурын бараа бүтээгдэхүүний төв”-ийг нээх чиглэлээр, Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой гамшиг, гэмт хэргийн зөрчлийн эсрэг хамтран ажиллах чиглэлээр тус тус харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд Бүгд найрамдах Хятад Ард Улсын Өвөр монголын өөртөө засах орны Манжуур хоттой туршлага солилцох уулзалтыг зохион байгуулж, 45 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, Шизуока мужийн Яйзу хотын иргэдийн сайн дурын бүлгэмийн ашиглагдаж байсан гал түймэр унтраах автомашиныг Чингэлтэй дүүрэгт бэлэглэж, хүлээн авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Тайлант онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Тамгын газрын дарга Дэн Юешэн тэргүүтэй зочид төлөөлөгчид, Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ишида Эрико тэргүүтэй зочид төлөөлөгчид, Бүгд Найрамдах Солонгос Улсын Өөртөө Засах Чэжү мужийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Буриад Улсын Улаан-Үүд хотын Зөвлөлтийн дүүргийн захиргааны дарга Эрдэниев Евгений Вячеславович тэргүүтэй зочид төлөөлөгчид, Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотын Засаг дарга тэргүүтэй зочид төлөөлөгчдийг тус тус Чингэлтэй дүүрэгт хүлээн авлаа.

Мөн Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Зафер Атештай албан уулзалтыг зохион байгуулж, тус улсад болсон байгалийн гамшиг, газар хөдлөлтөд нэрвэгдсэн иргэдэд тусламж үзүүлэх хүрээнд өргөө цагаан гэрийг хандивлалаа.

Дотоод томилолт, арга хэмжээний хүрээнд Увс аймгийн Улаангом сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй зочид, төлөөлөгчид, Дорноговь аймгийн сумдын нарийн бичгийн дарга нарын зочид төлөөлөгчдийг Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, Дархан хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай очиж харилцан туршлага солилцлоо.

Гадаад дотоодын олон улсын байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр “Дэээрэт” олон улсын энэрлийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төв, хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, айл өрхөд хүнсний тусламжийн багц, сургууль цэцэрлэгүүдэд гал тогооны тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, хичээлийн хэрэгсэл, зэрэг хандив, тусламжийг хамтран үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд гадаад дотоод хамтын ажиллагааны хүрээнд 11 ажлыг зохион байгуулж, биелэлт 100 хувьтай байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Хурлын Ажлын албанаас зохион байгуулсан үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд бодитой, шуурхай, өргөн мэдээллийг тогтмол өгч ажиллах зорилгоор “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Тайлант онд Хурал, Зөвлөлөөс баталсан тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт, зохион байгуулсан үйл ажиллагаа болон цаг үеийн 488 удаагийн мэдээлэл байршуулснаас 304 цагаан мэдээ, 33 видео шторк, 63 постер, бусад төрлийн 88 мэдээ мэдээлэл, хурлын даргын мэндчилгээ, аян, уралдааны талаарх 12 постер бэлтгэн иргэд олон нийтэд сурталчиллаа.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудас, www.chingelteicouncil.mn веб сайтаар 232 мэдээ, www.chingeltei.ub.khural.mn веб сайтаар 134 мэдээ, мэдээллийг байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан ажилласан байна. Хурлын www.chingelteicouncil.mn цахим хуудсанд давхардсан тоогоор 7012, www.chingeltei.ub.khural.mn цахим хуудсанд 18476, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар 86,600 хэрэглэгч хандаж мэдээлэл авсан байна.

Хурлын байгууллагаас баталсан шийдвэр, үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн цахим оролцоо, санал санаачилгыг хүлээн авах зорилгоор 1-24 дүгээр хороодын Иргэний танхимын цахим хаягт байршуулсан мэдээлэл, иргэдийн хандалтын тайланг сар бүр нэгтгэж, мэдээллийн үр дүнг тооцон ажиллаж байна. Тайлант онд Иргэний танхимын цахим хаягаар нийт 8631 удаагийн мэдээ мэдээлэл бэлтгэн нийтэлж, давхардсан тоогоор 66,161 иргэний хандалт авч, иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Тайлант онд нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, Улсын Их Хурал, Засгийн газар, дээд газрын болон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг мэдээллийн хэрэгсэл ашиглан иргэд, олон нийтэд цаг алдалгүй шуурхай хүргэх зорилгоор ТВ8 телевиз, “Монголын мэдээ” цахим сайттай гэрээ байгуулан хамтран ажиллалаа.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах хүрээнд Хурлын байгууллагын санхүүгийн сар, улирлын гүйцэтгэлийн тайлан, мэдээг тогтсон хугацаанд Шилэн

дансанд тогтмол байршуулж, иргэд, олон нийтийн мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Тайлант онд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 16, 37 дугаар захирамжийн хүрээнд Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр нийт 2379 зарлагын гүйлгээг анхан шатны баримт бичгийн бүрдэлд үндэслэн хийж гүйцэтгэн, мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлж, ажиллалаа.

Мөн Нийслэлийн аудитын газраас 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баримт, холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэн “Зөрчилгүй, санал, дүгнэлт” үнэлгээ авч ажилласан байна.

Тайлант онд Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн заавар, зөвлөмжийг байгууллагын ХАСХОМ гаргагч нарт шуурхай хүргэж, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын 2022 оны мэдүүлгийг цахимаар хүлээн авсан бөгөөд Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, дүүрэг, хороодын Засаг дарга нийт 46 албан тушаалтныг бүртгэн, хуулийн хугацаанд нь тайлан мэдээг хүргүүлж ажиллалаа.

Авлигатай тэмцэх газар, Хурлын байгууллагаас дэвшүүлсэн зорилтод тулгуурлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг эрчимжүүлэх, Авлигын эсрэг хууль тогтоомж, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлийн 14 ажлыг зохион байгуулж, хэрэгжилт 93,3 хувьтай байна.

ТАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд:

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын үйл ажиллагаа:

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос Улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг эрчимжүүлэх олон талт арга хэмжээг Улсын хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөний хүрээнд Чингэлтэй дүүргийн салбар комиссоос 2023 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн харьяат улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран зохион

байгуулж, хэлмэгдэгсдийн хойдын буянд зориулж зул өргөн, буяны ном хуруулж, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардууллаа. Тус үйл ажиллагаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн үр хүүхэд, тэдний гэр бүл 100 гаруй иргэн оролцлоо.

Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн бүртгэл судалгаанд хамрагдах иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч, бүртгэл судалгааг тухай бүр шинэчлэн баяжуулж, мэдээллийн санд бүртгэн ажиллаж байгаа бөгөөд нөхөн олговор хүссэн нийт 18 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст уламжлан, шүүхийн болон холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн тус бүр 40 сая төгрөгийн нөхөн олговрыг олгосон байна.

Тайлант онд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэдээс цахимаар санал авах ажлыг зохион байгууллаа. Цахим санал асуулгад дүүргийн 184 иргэн оролцсоноос 169 иргэн дэмжиж, 15 иргэн дэмжээгүй байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улс, Нийслэлийн комиссоос ирүүлсэн чиглэлийн дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэлтийн хор уршгийг ухуулан таниулах хүрээнд “Түүхээ мэдье” уралдаант арга хэмжээг дүүргийн харьяа ерөнхий боловсролын сургуулиудын түүх, нийгмийн ухааны арга зүйн хамт олны дунд олон талт хэлбэрээр зохион байгуулж, тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнэж, шагнаж урамшууллаа.

Мөн “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх төгөл”-ийг дүүргийн 19 дүгээр хороо, Хайрхан хөгжлийн төвд байгуулан, дурсгалын гэрэлт хөшөөг байрлууллаа.

Дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөл 2023 онд нийт 9 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 8 ажлыг бүрэн зохион байгуулж, 1 ажил хэрэгжих шатандаа байна.

Гамшгийн эрсдийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн үйл ажиллагаа:

Хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах үүрэг бүхий Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн бүрэлдэхүүнд 7 байгууллагын төлөөлөл бүхий 19 хүн ажиллаж байна.

Дүүрийн хэмжээнд 2023 онд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэлээр 3 бүлэг бүхий 17 ажлыг зохион байгуулахаас 15 ажлыг бүрэн зохион байгуулж, хэрэгжилт 88,2 хувь байна.

Тайлант онд гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий дүүргийн Онцгой байдлын хэлтэс, харьяа аврах, гал унтраах ангийн техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд үер усны аюулт

үзэгдэл, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан хор уршгийг арилгах, авран туслах ажиллагаанд ашиглах ус зайлуулах насос, тус хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай ухаалаг дэлгэцийн хөл, 60 ширхэг сандал зэрэг тавилга, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн бөгөөд сургалт, сурталчилгааны ажилд дэмжлэг үзүүлэх хүрээнд “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлаа хангах нь” сэдэвт 2000 ширхэг тараах материал, Байгалийн гамшигт үзэгдэл, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, санамж, зөвлөмж мэдээлэл бүхий “Чингэлбаатар хүүгийн адал явдал” цуврал зурагт ном, “Шар өвс шатахуунтай адил” нөлөөллийн аяны үйл ажиллагааг дэмжиж, тараах материал 1000 ширхэг, сурталчилгааны самбар 3 ширхэг, сэрэмжлүүлэх самбар 10 ширхэг, зөөврийн чанга яригч 1 ширхэг, шатахууныг зардлыг тус тус шийдвэрлэж, хамтран ажиллалаа.

Мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд үерийн улмаас эвдэрч сүйдсэн үерийн далан суваг, борооны ус зайлуулах ил далд шугам сүлжээний засвар үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг шийдвэрлэлээ.

Тайлант онд дүүргийн ерөнхий боловсролын 17 сургуулийн 140 гаруй өсвөрийн аврагч бүлгийн гишүүдэд болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, осол гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, анхны тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн заавар, зөвлөмжөөр хангах чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, гамшгаас хамгаалах сайн дурын гишүүдийг чадавхжуулах, сургагч багшаар бэлтгэх “Бэлэн бай” сургалтад шаардагдах зардлыг санхүүжүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Мөн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажилд төр, хувийн хэвшил, иргэд, олон нийтийг татан оролцуулах ажлын хүрээнд дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн гишүүдийг гамшгийн үед ажиллахад өмсөх хамгаалах хувцас хэрэгслээр хангаж ажиллалаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшгийн аюулыг иргэдэд цаг алдалгүй мэдээлэх зарлан мэдээллийн дуут дохиог дүүргийн 15, 16 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаа:

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2023 онд 36 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 35 ажил бүрэн хэрэгжиж, 1 ажил хойшилж, биелэлт 97,2 хувьтай байна.

Тайлант хугацаанд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 11 удаа хуралдаж, төлөвлөгөөт болон цаг үеийн 75

асуудлыг хэлэлцэн, 75 (давхардсан тоогоор) тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр дараах аян, арга хэмжээг санхүүжүүллээ. Үүнд:

- Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрийг угтан “Шийтгэл бол шийдэл биш” 1 сарын аян;
- Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд ой хээрийн болон өнжмөн шар өвсний гал түймрээс урьдчилан сэргийлэх “Шар өвс шатахуунтай адил” нөлөөллийн аян;
- Болзошгүй гал түймрийн аюулд хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө өртөх эрсдэлийг бууруулах, түүний шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр иргэд, олон нийтэд зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэх зорилго бүхий “Өнтэй өвөлжье–Эрсдэлгүй Чингэлтэй” аян;
- Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, тулгамдаж байгаа асуудлыг иргэд, олон нийтийн оролцоотойгоор шийдвэрлэх “Хүн бүр байгаль хамгаалагч” нөлөөллийн ажил;
- Гэр бүлийн үчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх, сайн дурын иргэдийн бүлэг байгуулах “Урам-2023” арга хэмжээ;
- Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэд, олон нийтэд цахим гэмт хэргийн талаар мэдээлэл хүргэх “Цахим орчин-залилан” арга хэмжээ;
- Дүүргийн нутаг дэвсгэр дэх зам тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах зорилго бүхий “Нэг зам-нэг соёл” арга хэмжээ;
- Архины хамааралтай, архи хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийн судалгааг гарган архинд донтох эмгэг, сэтгэцийн эмгэгийг тодорхойлон оношлох, архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах “Та татгалз” нэгдсэн арга хэмжээ;
- Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороод, Өрхийн Эрүүл Мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд болон халамж үйлчилгээний төвийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, кейс дээр ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх, хүнд кейс дээр зөвлөлдөн суралцах “Кейс хэлэлцүүлэг” арга хэмжээ;
- Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах, тэдний эцэг эх асран хамгаалагч

нарын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилго бүхий “Ногоон гэрэл-цагаан шугам 2023” тэмцээн;

- “Өсвөрийн сэргийлэгч 2023” тэмцээн
- Бяцхан зорчигч хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд төрийн болон хувийн өмчийн сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх “Аюулгүй тээвэрлэлт-аюулгүй зорчигч” сургалт;
- Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодын одонтой, залуу ээж нарт зориулсан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалт;
- Гамшгийн эрсдлийг бууруулах хүрээнд сайн дурын гишүүдийг чадавхжуулах, сургагч башгаар бэлтгэх “Бэлэн бай” сургалт;
- Гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, хууль зүйн мэдлэг өгөх, соён гэгээрүүлэх зорилгоор “Бид дахин алдахгүй” сургалт;
- Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулж буй “Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурал
- Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээ, Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтын ажил;

Дээрх аян, арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлаас дурдвал:

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд:

- Дүүргийн 24 дүгээр хороо Жигжид зуслангийн аманд байрлах булгийн эхийг хамгаалалтад авах, үүсмэл хогийн цэг үүсэхээс урьдчилан сэргийлэх хүрээнд анхааруулга, нөлөөллийн самбар;

“Шийтгэл бол шийдэл биш” 1 сарын аяны хүрээнд:

- Хүүхдийн бие махбодь, сэтгэл санааны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, тэдний эрхийг хамгаалах, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн эерэг аргыг сурталчлах “Шийтгэл бол шийдэл биш” аян зохион байгуулах ажлын хэсэг байгуулав;
- Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эцэг эх, сургуулийн удирдлага, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг улам бэхжүүлэх зорилго бүхий “Хамтдаа хамгаалъя” сургалт нөлөөллийн арга хэмжээ;

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэл бүхий нөхцөлд хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчтайгаа үнэ төлбөргүй холбогдоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дүүргийн ерөнхий боловсролын 5, 17, 24, 37, 39, 49, 50, 57, 61, 72, 139 дүгээр сургуулиудад “Итгэлтэй утас” суурьлуулан, ажиллуулж эхэллээ.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Ногоон бүс” төслийн хүрээнд дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт 85 ширхэг камер суурьлуулж, камерын хяналтыг бий болгов.

Мансууруулах эм сэтгэцэт нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор эмийн сан, эмийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж чиглэл хүргүүлж, хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэв.

Түүнчлэн тайлант хугацаанд Авлигын уршгийг ухуулан таниулах, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах тараах материал хэвлүүлэн тараалаа.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх хүрээнд дараах байгууллагуудад техник, тоног төхөөрөмжийн туслалцаа, дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад ашиглах нисдэг камер (дрон), энгэрийн камерийн бичлэг хуулагч, чанга яригч цагаан хоолой, цахилгаан скүүтэр 5 ширхэгийг тус тус дүүргийн Цагдаагийн газарт;
- Дүүргийн Прокурорын газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, яриа таниулга хийх, хэргийн газрыг дүрсжүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд ашиглах 10 ширхэг таблет, зөөврийн компьютерийг;
- “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хүрээнд 4 суурин компьютерийн иж бүрдэл, 4 ширхэг өнгөт принтерийг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зорчих хэсгийг хэсэгчлэн хаах, зам тээврийн осол хэргийн газрыг хамгаалалтад авахад шаардагдах техник хэрэгслийг дүүргийн Замын цагдаагийн хэлтэст;
- Нийтийн хэв журмыг хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, чиглэлээр ажиллаж буй албан хаагчдад торгууль хэвлэх төхөөрөмжийн карт сунгалтыг хэвлэх цаас, автомашины бүрэн бүтэн байдлыг санхүүжүүлж, ажиллах нөхцөлөөр хангасан байна.

Мөн хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн 221 дүгээр цэцэрлэгийн дотор орчинд хяналтын камерыг суурилуулахад дэмжлэг үзүүлж, холбогдох техник хэрэгслийг худалдаж авахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.

Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэг орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын 10 сургуулийн үзэгдэх орчин хязгаарлагдмал замын хэсэгт тэмдэг тэмдэглэгээ, толь байршууллаа.



Тайлант онд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээг хамтран үзүүлэх чиг үүрэг бүхий 1-24 дүгээр хороодын хамтарсан багийг ажиллах нөхцөлөөр хангах хүрээнд сар бүр шатахууны зардлыг санхүүжүүлж, багийн гишүүдийг чадавхжуулах, цогц мэдээлэл өгөх, зөвлөн туслах уулзалтыг тухай бүр зохион байгуулж, шилдэг хамтарсан багийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.

Мөн хамтарсан багийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, сурталчлах, идэвхжүүлэх хүрээнд дүүргийн 7, 9, 18 дугаар хороодын хамтарсан багт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.

Түүнчлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий сайн дурын 463 иргэд гудамж, байрны нийтийн эргүүлээр ажиллаж байгаа бөгөөд сар бүр ажилласан байдлыг нь харгалзан мөнгөн шагналаар шагнаж урамшуулан, ажиллах нөхцөлөөр хангаж байна.

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА